

# ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.06.02



## Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

### ТОВЧ

- Уул уурхайн салбарын гол хөдөлгүүр нь зэсийн баяжмал
- Нийт бэлэн бус төлбөр тооцооны зах зээлийн 10.4 хувийг QPAY эзэлж байна
- ТОП-20 индексийн үнэ 4-р сараас хойш сэргэлээ

### МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	0.08%	-4.30%	25.47%
MSE A	-0.25%	-4.40%	20.27%
MSE B	-1.99%	-4.80%	34.89%
2025/05/26 – 2025/05/30			

### Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
KHAN	777,790,001.00
AARD	550,854,007.00
ТАН	477,341,020.00
ХАС	441,376,602.61
ERDN	384,295,132.00
2025/05/26 – 2025/05/30	

### Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
CNF	51,350.00	31.30%
AARD	2,778.00	15.80%
SIL	50.60	15.00%
OLL	23.00	15.00%
HGS	9,050.00	14.99%
2025/05/26 – 2025/05/30		

2025 он 06-р сарын 02

Зах зээлийн  
үнэлгээ тэрбум ₮

**12,304**

ТОП-20 индекс

**49,595**

MSE A

**18,044**

MSE B

**14,433**



### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

**2.4%**

2024 - I улирал

Инфляц

**8.6%**

2025-04 сар

ГВУН(сая\$)

**5,135.39**

2025-04 сар

Бодлогын

хүү

**12.0%**

ЗГ-ын бондын  
өгөөж

**7.3%**

USD/MNT

**3,573.95**

2025-06-01



## Эдийн засгийн мэдээлэл

## МУ-ЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ГОЛ ХӨДӨЛГҮҮР НЬ ЗЭСИЙН БАЯЖМАЛ БАЙЛАА



2025 оны эхний улиралд Монгол Улсын уул уурхайн салбар 0.8 хувийн өсөлт үзүүлж, эдийн засгийн гол тулгуур хэвээр байгаагаа харууллаа. Энэхүү өсөлтөд хамгийн хүчтэй нөлөө үзүүлсэн хүчин зүйл нь зэсийн баяжмалын үйлдвэрлэлийн огцом өсөлт байв. Тодруулбал, зэсийн баяжмалын үйлдвэрлэл 448 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 29 хувиар өссөн нь салбарын ерөнхий өсөлтөд голлон нөлөөлжээ.

Харин нүүрс, алт, газрын тос болон төмрийн хүдрийн үйлдвэрлэлд харьцангуй бууралт ажиглагдлаа:

- Нүүрс: 20 сая тонн (өмнөх оны мөн үеэс 9 хувиар буурсан)
- Төмрийн хүдэр: Үйлдвэрлэл 4 хувиар буурсан
- Газрын тос: Үйлдвэрлэл 12 хувиар буурсан
- Алт: Үйлдвэрлэл 9 хувиар буурсан

2025 оны эхний дөрвөн сарын байдлаар (4-р сарын эцсийн дүнгээр) уул уурхайн бүтээгдэхүүн Монгол Улсын нийт экспортын 94 хувийг бүрдүүлсэн бөгөөд нүүрс болон зэсийн баяжмал хоёр дангаараа нийт экспортын 88 хувийг эзэлж байна.

График 1. Уул уурхай (бодит ДНБ-н өсөлт, хувь)



- Нүүрсний экспорт: 25.0 сая тонн (өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар буурсан)
- Зэсийн баяжмалын экспорт: 649 мянган тонн (өмнөх оны мөн үеэс 29.9 хувиар өссөн)
- Төмрийн хүдрийн экспорт: 2.45 сая тонн (өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар өссөн)
- Газрын тосны экспорт: 1.16 сая баррель (өмнөх оны мөн үеэс 17.4 хувиар өссөн)

Зэсийн экспортын огцом өсөлт нь дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлттэй шууд холбоотой байв. Тухайлбал, Лондоны металлын бирж дээр 2025 оны дөрөвдүгээр сарын дундаж үнэ тонн тутамд 9,477 ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 6 хувиар нэмэгджээ.

## ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС 50.3 ГАРЛАА



Үйлдвэрлэлийн индексийн утгыг эдийн засгийн өсөлттэй (бодит ДНБий жилийн өөрчлөлт) харьцуулахад үйлдвэрлэлийн индексийн утга 50- аас их гарсан дийлэнх үеүдэд эдийн засаг өсөлттэй гарчээ. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлийн индексийн утга нь бодит ДНБ-ий өсөлтийг тайлбарлах чадвар өндөр байна. Энэ улирлын үйлдвэрлэлийн индексийн утга 50.3 гарсан бөгөөд 2025 оны I улиралд эдийн засаг өсөлттэй гарах боловч өмнөх улирлын эдийн засгийн өсөлтийн хурдац саарах төлөвтэй байна



## Зах зээлийн мэдээлэл

### ОНЦЛОХ КОМПАНИ: ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ

Инновэйшн Инвестмэнт ХХК нь QPay үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааг удирдах “ККТТ” ХХК, Мерчантуудад чиглэсэн үйлчилгээнүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах “Дижитал Мерчант Сервисэс” ХХК гэх хоёр охин компанитай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд группын толгой компани Инновэйшн Инвестмэнт ХХК нь группийн шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлт, хөрөнгө оруулалт, одоогийн бэлэн бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжил, тэлэлтийг удирдан ажиллаж байна.

“Инновэйшн Инвестмент” ХК-ийн хөгжүүлсэн QPay үйлчилгээ нь Монгол Улсад дотооддоо боловсруулсан хамгийн өргөн хэрэглээтэй төлбөр тооцооны системийн нэгээр зүй ёсоор тооцогдож байна. 2025 оны эхний улирлын байдлаар тус системээр өдөрт дунджаар 576.6 мянган гүйлгээ, 39.5 тэрбум төгрөгийн дүнтэй дамжин боловсруулагдаж байна.


Бэлэн бус төлбөрийн хэрэглээ өсөж буйг даган QPay үйлчилгээний зах зээл дэх байр суурь улам бэхжиж байгаа бөгөөд 2024 онд нийт бэлэн бус төлбөрийн зах зээлийн 8.5 хувийг эзэлж байсан бол 2025 онд энэ үзүүлэлт 10.2 хувь-д хүрэхээр байна.

Санхүүгийн үзүүлэлтүүд ч өсөлттэй байна. 2025 оны эхний улирлын байдлаар компанийн цэвэр ашиг 3.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35.7%-иар, харин борлуулалтын орлого 7.5 тэрбум төгрөг болж 55.1%-ийн өсөлттэй гарчээ. Компанийн 2025 оны санхүүгийн төлөвлөгөөгөөр жилийн эцэст цэвэр ашиг 12 тэрбум төгрөгт хүрэхээр байгаа нь IPO хийх үеийн таамаглалаас 14.2%-иар өндөр үзүүлэлт болох төлөвтэй байна.

### ТОП-20 ИНДЕКСИЙН ГҮЙЦЭТГЭЛ 4-Р САРААС ХОЙШ СЭРГЭЛЭЭ

2025 оны эхний дөрвөн сарын байдлаар үнэт цаасны зах зээлд нийт 260.1 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 25.8 тэрбум төгрөгөөр (11.0%) өссөн үзүүлэлт болж байна. Үүнээс анхдагч зах зээлийн арилжаа 68.0 тэрбум төгрөгөөр (26.2%), хоёрдогч зах зээлийн арилжаа 192.0 тэрбум төгрөгөөр (73.8%) тус тус бүрдүүлжээ.

График 3. ТОП-20 индекс (оны эхнээс)



Нийт гүйлгээний бүтцийг авч үзвэл:

- 41.5 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас,
- 26.8 хувийг компанийн бонд,
- 23.9 хувийг компанийн хувьцаа,
- 7.4 хувийг Засгийн газрын бонд,
- 0.3 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх тус тус эзэлж байна.

Түүнчлэн, зөвхөн 2025 оны 4 дүгээр сард үнэт цаасны арилжаа 87.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 41.2 тэрбум төгрөгөөр (89.0%), өмнөх сараас 23.0 тэрбум төгрөгөөр (35.6%) тус тус өссөн нь зах зээл идэвхжиж буйг илтгэж байна.




## ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	ДУНДАЖ
1 сар	-2.10%	-1.00%	5.40%	-4.20%	7.50%	0.90%	10.50%	1.90%	3.50%	7.00%	2.90%	2.90%
2 сар	-3.50%	-3.00%	-0.90%	-0.10%	-0.60%	-0.90%	29.20%	-4.60%	2.40%	5.50%	1.70%	2.30%
3 сар	-3.50%	-5.10%	4.60%	-1.00%	-2.60%	-4.00%	31.20%	-6.10%	0.50%	1.90%		1.60%
4 сар	-3.00%	-1.50%	2.50%	-4.60%	-3.70%	-8.70%	4.10%	-0.90%	-5.20%	-3.30%		-2.40%
5 сар	-2.40%	-1.20%	-1.60%	-2.00%	0.30%	-2.10%	1.20%	-6.70%	0.50%	-0.40%		-1.40%
6 сар	13.90%	5.20%	-1.60%	0.90%	-1.80%	-1.00%	-7.70%	-3.70%	-0.60%	0.80%		0.50%
7 сар	-2.60%	10.80%	8.20%	-1.00%	3.60%	2.00%	-1.10%	-0.80%	1.10%	9.80%		3.00%
8 сар	-6.70%	-1.80%	8.70%	-0.90%	-2.80%	1.60%	7.70%	4.60%	0.00%	3.50%		1.40%
9 сар	-0.40%	-7.40%	16.60%	3.50%	-3.20%	2.70%	27.50%	-1.50%	-5.40%	-1.30%		3.10%
10 сар	-0.60%	-2.70%	16.90%	2.10%	-3.60%	1.60%	-10.00%	-1.90%	0.60%	0.20%		0.30%
11 сар	-2.90%	-3.40%	9.30%	-2.00%	0.00%	0.50%	-2.40%	1.10%	4.60%	1.80%		0.70%
12 сар	-3.60%	7.00%	0.10%	0.10%	1.90%	3.30%	5.80%	5.40%	5.00%	2.00%		2.70%

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

### Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.